



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мандал сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/246-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2024 он	ТАГ-ын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитыг гүйцэтгэсэн: "Пийк Ом Аудит" ХХК Утас: 99052418 Цахим хаяг: cheegii9989@gmail.com
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	4-5
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6-12
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	13-17
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13-14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	14-15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15-17
4. Аудитын тайлан	17-20
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19-20
5. Аудитын илрүүлэлт	21-22
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	23

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БЕГ	Боловсролын ерөнхий газар
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
НА	Нийцлийн аудит
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТАГ	Төрийн аудитын газар
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр ажил үйлчилгээ худалдах авах тухай
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

МАНДАЛ СУМЫН 4 ДҮГЭЭР
ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Л.ГАНТӨМӨР ТАНАА

2024.8.23 № САА-2024/246-САА-ДН-ТЧЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мандал сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд иргэдээс 15,905.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, бусад хөрөнгийг хандиваар хүлээн авсан байна.

Аудитын гол асуудал

Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 49 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 100.0 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	47,363,446.32	65,589,462.21
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	30,056,241.32	46,927,932.21
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	30,056,241.32	46,927,932.21
31210	Төгрөг	30,056,241.32	46,927,932.21
31211	Төрийн сангийн харилцах	30,056,241.32	46,927,932.21
35	БАРАА МАТЕРИАЛ	17,307,205.00	18,661,530.00
35400	Хангамжийн материал	17,307,205.00	18,661,530.00
35410	Бичиг хэргийн материал	112,900.00	112,900.00
35420	Аж ахуйн материал	3,251,100.00	3,251,100.00
35450	Барилгын засварын материал	1,134,800.00	1,134,800.00
35460	Хүнсний материал	1,274,150.00	524,275.00
35470	Бусад хангамжийн материал	11,534,255.00	13,638,455.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	879,020,124.44	867,970,201.53
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	879,020,124.44	867,970,201.53
39200	Биет хөрөнгө	845,995,124.34	835,195,201.39
39201	Барилга, байгууламж, орон сууц	930,000,000.00	930,000,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-118,833,333.62	-134,333,333.66
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	43,642,400.00	55,642,400.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-28,933,107.02	-34,031,477.06
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	21,481,208.62	25,066,208.62
39208	Хуримтлагдсан элэгдэл	-14,148,226.88	-16,954,514.32
39214	Бусад үндсэн хөрөнгө	20,844,712.90	21,164,712.90
39215	Хуримтлагдсан элэгдэл	-8,058,529.66	-11,358,795.09
39300	Биет бус хөрөнгө	33,025,000.10	32,775,000.14
39301	Программ хангамж	1,250,000.00	1,250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-624,999.90	-874,999.86
39303	Бусад биет бус хөрөнгө	32,400,000.00	32,400,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	926,383,570.76	933,559,663.74
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	926,383,570.76	933,559,663.74
51	Засгийн газрын хувь оролцоо	926,383,570.76	933,559,663.74
51100	Засгийн газрын оруулсан капитал	32,400,000.00	32,400,000.00
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	32,400,000.00	32,400,000.00
51200	Хуримтлагдсан үр дүн	893,983,570.76	901,159,663.74
51210	Өмнөх үеийн үр дүн	-32,400,000.00	893,983,570.76
51220	Тайлант үеийн үр дүн	926,383,570.76	7,176,092.98
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	926,383,570.76	933,559,663.74

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,313,745,925.77	468,499,878.41
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	928,833,274.14	16,105,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	928,833,274.14	16,105,000.00

120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	905,247,939.14	15,905,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	23,585,335.00	200,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	384,912,651.63	452,394,878.41
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	322,051,100.00	405,989,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	322,051,100.00	405,989,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	62,861,551.63	46,404,978.41
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	62,861,551.63	46,404,978.41
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	387,362,355.01	461,323,785.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	387,362,355.01	461,323,785.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	387,362,355.01	461,323,785.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	247,813,094.87	312,269,606.39
210101	Үндсэн цалин	187,912,245.64	215,479,754.58
210102	Нэмэгдэл	51,277,883.82	83,186,361.91
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	0.00
210104	Урамшуулал	8,622,965.41	13,603,489.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,351,440.04	36,981,522.72
210201	Тэтгэврийн даатгал	21,900,132.35	25,425,339.50
210202	Тэтгэмжийн даатгал	2,112,878.42	2,699,761.74
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,690,321.08	2,362,577.00
210204	Ажилгүйдлийн даатгал	422,654.82	589,579.35
210205	Эрүүл мэндийн даатгал	4,225,453.37	5,904,265.13
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,333,779.40	23,206,578.41
210301	Гэрэл, цахилгаан	4,340,497.40	6,104,618.41
210302	Түлш, халаалт	12,221,000.00	15,280,000.00
210303	Цэвэр, бохир ус	3,772,282.00	1,821,960.00
2104	Хангамж, бараа материалын зардал	892,000.00	0.00
2105	Нормативт зардал	21,971,980.00	29,669,725.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,500.00	0.00
210502	Хоол, хүнс	21,948,980.00	29,669,725.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	20,500.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,230,328.00	23,198,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	255,000.00	0.00
210604	Урсгал засвар	29,975,328.00	23,198,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	208,250.00	736,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	150,000.00	736,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	35,561,482.70	35,261,552.91
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,377,668.00	6,502,330.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,956,000.00	1,804,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	26,227,814.70	26,954,922.91
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	926,383,570.76	7,176,092.98
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	926,383,570.76	7,176,092.98

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	384,912,651.63	452,394,878.41
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	384,912,651.63	452,394,878.41
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	322,051,100.00	405,989,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	322,051,100.00	405,989,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	62,861,551.63	46,404,978.41
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	62,861,551.63	46,404,978.41
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	354,856,410.31	435,523,187.52
21	УРСГАЛ ЗАРДАЛ	354,856,410.31	435,523,187.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	354,856,410.31	435,523,187.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	247,813,094.87	312,269,606.39
210101	Үндсэн цалин	187,912,245.64	215,479,754.58
210102	Нэмэгдэл	51,277,883.82	83,186,361.91
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	0.00
210104	Урамшуулал	8,622,965.41	13,603,489.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,351,440.04	36,981,522.72
210201	Тэтгэврийн даатгал	21,900,132.35	25,151,194.53
210202	Тэтгэмжийн даатгал	2,112,877.88	2,973,906.71
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,690,321.08	2,362,577.00
210204	Ажилгүйдлийн даатгал	422,655.36	589,579.35
210205	Эрүүл мэндийн даатгал	4,225,453.37	5,904,265.13
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	0.00	0.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,333,779.40	23,206,578.41
210301	Гэрэл, цахилгаан	4,340,497.40	6,104,618.41
210302	Түлш, халаалт	12,221,000.00	15,280,000.00
210303	Цэвэр, бохир ус	3,772,282.00	1,821,960.00
2105	Нормативт зардал	21,609,000.00	28,919,850.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	0.00
210502	Хоол, хүнс	21,609,000.00	28,919,850.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,890,228.00	23,198,400.00
210604	Урсгал засвар	24,890,228.00	23,198,400.00
2107	Томилолт, зочны зардал	0.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	150,000.00	601,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	150,000.00	601,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,708,868.00	10,345,830.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,708,868.00	8,541,530.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,000,000.00	1,804,300.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	30,056,241.32	16,871,690.89
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	30,056,241.32	16,871,690.89
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	30,056,241.32
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	30,056,241.32	46,927,932.21

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	32,400,000.00	0.00	893,983,570.76	926,383,570.76
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	32,400,000.00	0.00	893,983,570.76	926,383,570.76
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	32,400,000.00	0.00	893,983,570.76	926,383,570.76
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	7,176,092.98	7,176,092.98
20	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	32,400,000.00	0.00	901,159,663.74	933,559,663.74

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	484,475,900.00	435,523,187.50	48,952,712.50	89.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	484,475,900.00	435,523,187.50	48,952,712.50	89.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	484,475,900.00	435,523,187.50	48,952,712.50	89.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	348,366,100.00	312,269,606.39	36,096,493.61	89.6
210101	Үндсэн цалин	231,029,300.00	215,479,754.58	15,549,545.42	93.3
210102	Нэмэгдэл	108,403,700.00	83,186,361.91	25,217,338.09	76.7
210104	Урамшуулал	8,933,100.00	13,603,489.90	-4,670,389.90	152.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,545,500.00	36,981,522.72	6,563,977.28	84.9
210201	Тэтгэврийн даатгал	29,611,000.00	25,151,194.53	4,459,805.47	84.9
210202	Тэтгэмжийн даатгал	3,483,700.00	2,973,906.71	509,793.29	85.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,786,900.00	2,362,577.00	424,323.00	84.8
210204	Ажилгүйдлийн даатгал	696,900.00	589,579.35	107,320.65	84.6
210205	Эрүүл мэндийн даатгал	6,967,000.00	5,904,265.13	1,062,734.87	84.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,231,300.00	23,206,578.41	2,024,721.59	92.0
210301	Гэрэл, цахилгаан	5,315,100.00	6,104,618.41	-789,518.41	114.9
210302	Түлш, халаалт	15,280,000.00	15,280,000.00	0.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	4,636,200.00	1,821,960.00	2,814,240.00	39.3
2105	Нормативт зардал	32,481,600.00	28,919,850.00	3,561,750.00	89.0
210502	Хоол, хүнс	32,481,600.00	28,919,850.00	3,561,750.00	89.0
210604	Урсгал засвар	23,198,400.00	23,198,400.00	0.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	601,400.00	601,400.00	0.00	100.0

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	601,400.00	601,400.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,051,600.00	10,345,830.00	705,770.00	93.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,247,300.00	8,541,530.00	705,770.00	92.4
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,804,300.00	1,804,300.00	0.00	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	484,475,900.00	452,394,878.41	32,081,021.59	93.4
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	484,475,900.00	452,394,878.41	32,081,021.59	93.4
310001	Улсын төсвөөс санхүүжих	405,989,900.00	405,989,900.00	0.00	100.0
320001	орон нутгийн санхүүжилт	48,429,700.00	46,404,978.41	2,024,721.59	95.8
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	30,056,300.00		30,056,300.00	
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	30,056,300.00		30,056,300.00	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	30,056,241.32	-30,056,241.32	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	46,927,932.21	-46,927,932.21	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Мандал сумын 4 дүгээр цэцэрлэг нь “Хамтын оролцоо, үнэлгээний үр дүнд суурилан боловсролын үйлчилгээний хүртээмж, чанар ахиц гаргах” гэсэн эрхэм зорилгыг дэвшүүлсэн байна.

Дээрх зорилгыг хэрэгжүүлэхээр дараах зорилтуудыг тодорхойлжээ. Үүнд:

- *Боловсролын ерөнхий хууль, сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийг суралцагч, эцэг эх, асран хамгаалагч, баш ажилтан олон нийтэд сурталчлан таниулах, тэдний оролцоотой хэрэгжүүлэх;*
- *Малчин болон алслагдсан бүс нутагт амьдарч байгаа өрхийн хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг сургалт үйл ажиллагаагаар дэмжих, 5 настай хүүхэд бүрийг СӨБ-н үйлчилгээнд хамруулан сургуульд элсэн суралцах бэлтгэл хангах;*
- *Тэгш хүртээмжтэй, тэгш боломж олгосон, хамтын хариуцлагатай байх, байршлаас хамаарсан үйлчилгээний чанарын ялгааг бууруулж хүүхэд бүр гэртээ ойр байрлах цэцэрлэг хамрагдах хүсэл эрмэлзлийг нэмэгдүүлэх;*
- *Хүүхэд бүрийн онцлог, ялгаатай байдал явцын үнэлгээнд суурилсан сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах үйл ажиллагааг үргэлжлүүлэн, үр дүнтэй хэрэгжүүлж, сурлагын амжилтад ахиц гаргах;*
- *Цэцэрлэгт суурилсан багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны бүтцийг бий болгож, ажлын гүйцэтгэл, үр дүнд суурилан багшийн мэргэжлийн хөгжлийн үндэсний цахим системийг ашиглан багш ажлын байрандаа мэргэжлээ дээшлүүлэх, ур чадварт гарсан ахиц үр дүнд тооцох,*

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Боловсролын ерөнхий хууль 2023 оны 07 дугаар сарын 07-нд батлагдсан,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон,
- БШУС-ын 2023 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн 1/2714 тоот албан бичгээр боловсролын байгууллагын төсвийн шинэчлэлийн хүрээнд 1."ЕБС-д сургалтын тоног төхөөрөмжийн нөхөн хангалт шийдвэрлэх", 2."Цэцэрлэгт шаардлагатай хүүхдийн тоглоом,наадгай, зөөлөн эдлэл ханган нийлүүлэх,худалдан авах ажиллагааг зохион байгуулах" чиглэлийг хүргүүлсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус цэцэрлэгийн санхүүгийн үйл ажиллагаанд БШУЯ-ны Хяналт, шинжилгээ үнэлгээний газрын Дотоод аудитын хэлтсээс хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мандал сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Мандал сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 7,176.1 мянган төгрөгөөр буюу 0.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	30,056.2	46,927.9	16,871.7
Авлага			
Бараа материал	17,307.2	18,661.5	1,354.3
Үндсэн хөрөнгө	879,020.1	867,970.2	(11,049.9)
Нийт хөрөнгө	926,383.6	933,559.7	7,176.1
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	926,383.6	933,559.7	7,176.1
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	926,383.6	933,559.7	7,176.1

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан дараах данснууд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 46,927.9 мянган төгрөг болж 16,871.7 мянган төгрөгөөр өссөн нь зардлын хэмнэлттэй холбоотой бөгөөд уг хэмнэлтийг Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9 дэх “Энэ хуулийн 7.7 дахь хэсэг эрүүл мэнд, боловсролын салбарын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зарчмаар санхүүждэг байгууллагын төсвийн захирагчид хамаарахгүй” гэж заасны дагуу төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсанаас,
- Бараа материал дансны үлдэгдэл 18,661.5 мянган төгрөг болж 1,354.3 мянган төгрөгөөр өссөн нь Дэлхийн зөн Монгол Зүүнхараа ОНХ сангаас 300.0 мянган төгрөгийн сонсдог ном, төсвийн хөрөнгөөр 56,941.1 мянган төгрөгийн бараа материал худалдан авч үйл ажиллагаанд 55,586.7 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 867,970.2 мянган төгрөг болж 11,049.9 мянган төгрөгөөр буурсан нь иргэдээс хандивласан 15,905.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, бусад хөрөнгийн үнэ төлбөргүй орлого, 26,954.9 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсоноос тус тус шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд улсын төсвөөс 271,188.2 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 48,429.7 мянган төгрөг, нийт 319,617.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, зарцуулахаар дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслийн өөрчлөлтгүй баталсан байна.

2023 онд төсөвт 3 удаа өөрчлөлт орж 11 дүгээр сард цалин хөлс, шимтгэлийн зардлыг 161,048.1 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 2,848.2 мянган төгрөгөөр, хүүхдийн хоолны зардлыг 967.7 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж нийт 484,475.9 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр нийт 452,394.8 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж урсгал үйл ажиллагаанд 435,523.2 мянган төгрөгийг зарцуулан, 2,024.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, 46,927.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 435,523.2 мянган төгрөг буюу 89.9 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 43,366.2 мянган төгрөгөөр, хүүхдийн хоолны зардлыг 3,561.7 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 2,024.8 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/						
д/д	Хөтөлбөр	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71802 сургуулийн өмнөх боловсрол	81605- Эрүүл мэндийг дэмжих	902.1	902.1	0.0	100.0
2		81807-Цэцэрлэгийн хүүхдийн хоол	32,481.6	28,919.9	3,561.8	89.0
3		81816- Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	1,834.2	1,834.2	0.0	100.0
4		81823- Боловсролын байгууллагын багш,	902.1	902.1	0.0	100.0
5		81434-Боловсролын стандарт, сургалтын	296,835.1	265,035.4	31,799.7	89.3
6		81835-Сургалтын хэвийн үйл ажиллагаа	103,091.1	91,524.6	11,566.5	88.8
7		80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	48,429.7	46,405.0	2,024.7	95.8
нийт			484,475.9	435,523.2	48,952.7	89.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн

гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан гүйцэтгэж, тайланг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, хоол хүнсний 32,400.0 мянган төгрөгийн бараа ажил үйлчилгээг гүйцэтгэх бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалтыг зарлаагүй, “Шанзан ташуур” ХХК, “Япсомо” ХХК, “Уужим хараа” ХХК ХХК-иудтай шууд гэрээ байгуулж худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Мандал сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Пийк Ом Аудит” ХХК-ийн аудитор Б.Наранчимэг, чанарын хяналтыг компанийн захирал Б.Жаргалсайхан, анхан шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, хоёр дахь шатны хяналтыг дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Мандал сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Пийк Ом Аудит” ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/15 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 387,362.3 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 3,787.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Мандал сумын 4 дүгээр цэцэрлэг Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн системийн мэдээлбэл зохих 20 төрлийн 145 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж дараах 4 мэдээллийг хугацаа хоцроосон байна. Үүнд:

- Дараа жилийн төсвийн төсөл -1
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө -1
- Хөрөнгийн зардал,хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл,концессын зүйлийн жагсаалт,гүйцэтгэл -1
- Хөрөнгийн зардал,хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө,концессын зүйлийн жагсаалт - 1

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд :

Орон нутагт хүнсний бүтээгдэхүүний бөөний төвлөрсөн цэг байхгүй, зах зээл хомс шалтгаанаар үнийн харьцуулалт хийлгүйгээр “Шанзан ташуур” ХХК, “Япсомо” ХХК, “Уужим хараа” ХХК ХХК – нуудтай шууд гэрээ байгуулж хоол, хүнсний худалдан авалтыг гүйцэтгэсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Захиалагч тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, худалдан авах ажиллагааны цахим систем болон хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримталж зохион байгуулах зөвлөмж,

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

“Пийк Ом аудит” ХХК-ийн 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 222 дүгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны 17 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилд албан шаардлага бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулж цахим системд шивээгүй 133.6 мянган төгрөгийн зөрчилд анхаарч ажиллах 1 зөвлөмж өгсөн байна.

Өмнөх оны аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 50.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	133.6	1	133.6	100.0
Албан шаардлага	1	0.0	0	0.0	0.0
Нийт дүн	2	133.6	1	133.6	50.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1.БШУЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн нь 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 2/3151 дүгээр албан бичгээр тус яамны харьяа төсвийн шууд

захирагч нарт “2022 оны санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, “ Итгэл үзүүлсэн”, “Түүвэрт хамрагдсан” гэж дүгнэгдсэн байгууллагуудын төсөв, санхүүгийн ажилтан нарт батлагдсан төсөвтөө багтаан балансын урамшууллыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 23.2 дахь хэсгийг үндэслэн олгож болно” гэж хууль, эрхийн актад заагдаагүй балансын урамшуулал гэгчийг олгохыг зөвшөөрсөн байна.

Уг албан бичгийн дагуу дараах албан хаагчдын ажлын үр дүнг улирал бүр дүгнэж, үндсэн цалингийн 45.0 хүртэл хувиар тооцон үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон атал тус бүр хоёр сарын үндсэн цалинтай тэнцэх буюу 1,564.4 мянган төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон байна. Үүнд:

- Нягтлан бодогч Н.Тунгалаг 875.3 мянган төгрөг,
- Нярав З.Мөнхтуяа 689.1 мянган төгрөг,

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно:”, 15.1.3 : “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2. Дээд шатны төсөв захирагчаас төсвийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна. Иймд төсвийг бодит гүйцэтгэлтэй нь уялдуулан зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж, зарцуулан гүйцэтгэж байх шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой 2,377.2 мянган төгрөгийг алдааг залруулсан. Үүнд:

- Тайлант онд 2,050.3 мянган төгрөгийн цалин, нийгмийн даатгалын зардлыг гүйлгэн тайлагнасан нь *УСННБОУС-1 Топилууллага ба тодруулга болон үнэн зөв байх* батламж мэдэгдлийг хангахгүй байна,
- Худалдан авсан 326.9 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэлгүй шууд зардлаар бүртгэсэн нь *УСННБОУС-1 Топилуулга ба тодруулга болон үнэн зөв байх* батламж мэдэгдлийг хангахгүй байна,

Аудитаар 3,605.6 мянган төгрөгийн зөрчил¹ илэрч ур чадварын нэмэгдлийг нөхөн төлүүлэх 931.6 мянган төгрөгийн төлбөрийн акт, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах 2,674.0 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлэв.

5.1 Төлбөрийн акт

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

1. Жилийн эцэс буюу тайлант оны 12 дугаар сард шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэлгүйгээр ур чадварын нэмэгдлийг 5 багшид 25.0 хувиар тооцон нийт /өмнөх саруудад 10-15 хувиар тооцож олгож байсан/ 931.6 мянган төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2021 оны 02 сарын 01-ний өдрийн А/35, А/102 дугаар хамтарсан “Шалгуур үзүүлэлт шинэчлэн батлах тухай” тушаалын 1 дүгээр хавсралтын 10 дахь “Энэхүү баримт бичгийн 4,5-д заасан шалгуур үзүүлэлтийн дагуу хийсэн үнэлгээнд 60.0 ба түүнээс дээш хувь үнэлэгдсэн багш, ажилтны ажлын үр дүн, манлайлал, мэргэжлийн хөгжлийн ахиц дэвшил, амжилтын түвшнийг харгалзан нэмэгдлийг дараах хувиар тогтооно.” “цэцэрлэг, сургуулийн түвшинд амжилт гаргасан 10 хувь” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Ур чадварын нэмэгдлийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох,

5.2 Албан шаардлага

1. Батлагдсан цалингийн зардлаас 4 багшид “Байгууллагын шилдэг ажилтан”, “Тэргүүн номинаци” гэх үндэслэлүүдээр шагналын зардалд **2,674.0** мянган төгрөгийг зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтуудыг болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, санхүүгийн тайланг анхан шатны баримтад үндэслэн үнэн зөв илэрхийлж байх албан шаардлага хүргүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс					
							Залруулсан		Запруулаагүй		Зөвлөмж	
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Цалин, нийгмийн даатгалын зардлыг гүйлгэн тайлагнасан	1	2,050.3			1	2,050.3	1	2,050.3				
Худалдан авсан бараа материалыг орлогоор бүртгэлгүй шууд зардлаар бүртгэсэн нь	1	326.9			1	326.9	1	326.9				
Дүн	2	2,377.2			2	2,377.2	2	2,377.2				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо
Тайлант жилийн эцэст шалгуур үзүүлэлтийг харгалзалгүй ур чадварын нэмэгдэл олгосон	1	931.6	1	931.6									
Батлагдсан цалингийн зардлаас 4 багшид үндэслэлүүдээр шагналын зардал гаргасан.	1	2,674.0			1	2,674.0							
Дүн	2	3,605.6	1	931.6	1	2,674.0							

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
шилэн дансны нэгдсэн системийн мэдээлбэл зохих 20 төрлийн 144 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж 5 мэдээллийг хугацаа хоцроосон байна.	1		1			

Дүн	1		1			
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Шууд гэрээ байгуулж хоол, хүнсний худалдан авалтыг гүйцэтгэсэн	1				1	
Дүн	1				1	
Нийт дүн	2		1		1	